



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
“ЧАНДМАНЬ – БАЯНХОНГОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 4

Номгон

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 15:30 цагт Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын өрөөнд эхлэв.

Хуралд: АИТХ-ын дарга Э.Энхбат, “Чандмань-Баянхонгор” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Батбаяр, Л.Мандал, Д.Даваадорж, Ц.Байгалмаа, Ч.Үйтүмэн, П.Дашзэвэг нар танхимаар, Ц.Төмөрбаатар, Д.Сайнжаргал нар онлайнаар оноролцов.

ТУЗ-ийн гишүүдийн ирц 88.8 хувьтай.

Хэлэлцэх асуудал:

1. “Чандмань-Баянхонгор” ХК-ийн ТУЗ-ийн даргыг сонгох
2. Компанийн гүйцэтгэх захирлыг томилох

СОНССОН нь:

Э:Энхбат: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор Чандмань-Баянхонгор ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл шинэчлэгдсэн байгуулагдсан байгаа. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Б.Батбаяр, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ц.Төмөрбаатар, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Д.Сайнжаргал, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч О.Мөнхбат, Аймгийн ИТХ-ын төлөөлөгч П.Дашзэвэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Ц.Байгалмаа, Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн Ч.Үйтүмэн, Иргэний төлөөлөл Л.Мандал, Д.Даваадорж гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

Аймгийн хурал бол Төлөөлөн удирдах зөвлөлийг баталж ажилд нь оруулах үндсэн үүрэгтэй. Тиймээс өнөөдрийн хурлыг зохион байгуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаярыг томилох саналыг гишүүдэд өргөн барьж байна. Энэ асуудлаа гишүүд дотроо зохион байгуулах ёстой. За ингээд хурлаа удирдан зохион байгуулаад явна уу гэж Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах мэргэжилтэн Ц.Байгальмааг үлдээж байна. Хурлаа удирдаад явна уу.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

2520907

Ц.Байгалмаа: Даргаар өөр санал оруулах саналтай гишүүн байна уу?

Б.Батбаяр: Компанийн дүрэмтэй эхлээд танилцах шаардлагатай байх.

Ц.Байгалмаа: Дүрмэн дээр юу гэж заасан байгаа вэ Мягмарсүрэн?

Ч.Мягмарсүрэн: Компанийн дүрмийн 7.10 дахь заалтанд ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар даргыг сонгоно гэж заасан байгаа.

П.Дашзэвэг: 1 дүгээрт нийтийн эрх ашгийн төлөө ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагаа учир саналаа хэлье. ТУЗ-н бүрэлдэхүүнд орсон тухай ямар нэгэн мэдээлэлгүй байсан. Ардчилсан намын бүлэг дээр яригдсан зүйл өөр байгаа учир ямар ч байсан хурлын процэсст хувь хүнийхээ хувьд оролцъё. ТУЗ-ийн гишүүнээр ажиллахаас татгалзаж байна. Тиймээс чөлөөлж өгөөч ээ гэж байна.

Ц.Байгалмаа. Аймгийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаас нэгэнт томилсон учир саналаа тэргүүлэгчдэд тавих хэрэгтэй.

Л.Мандал: Шалтгааныг нь тодруулмаар байна.

П.Дашзэвэг Бүлгийн шийдвэр арай өөр байгаа. Тохиролцоо яриагаа арай хийж дуусаагүй байна. Тэрнээс шалтгаалах байх. Ямартай ч хуралдаа оролцъё.

Санал оруулсан Б.Батбаярыг дэмжиж байна.

Даваадорж: Б.Батбаяр төлөөлөгчийг дэмжиж байна. Өөр саналгүй

Л.Мандал. Дэмжиж байна.

Ц.Байгалмаа: Санал хураая.

| № | ТУЗ-ийн гишүүний овог нэр | Санал өгсөн байдал | | |
|---|---------------------------|--------------------|------------|------------|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түтгэлзсэн |
| 1 | П.Дашзэвэг | + | | |
| 2 | Л.Мандал | + | | |
| 3 | Д.Даваадорж | + | | |
| 4 | Ц.Байгалмаа | + | | |
| 5 | Ч.Үйтүмэн | + | | |

Ц.Байгалмаа: Онлайнаар оролцож байгаа 2 хүнийхээ саналыг сонсоё.

Ц.Төмөрбаатар: Өөр санал алга. ТУЗ-ийн гишүүнээр өмнө нь ажиллаж байсан. Энэ удаагийнхд байх шаардлага алга. Тиймээс нэрээ татаа саналтай байна.

Ц.Байгалмаа: Нэгэнт томилогдоод энэ удаагийн хуралд ирж чинь бүртгэгдээд орсон учир энэ удаагийн хуралдаа оролцсон нь зүйтэй байх. Тэргүүлэгчдэд бичгээр саналаа өгөөрэй.

Ц.Төмөрбаатар: ТУЗ-ийн даргаар Ц.Төмөрбаатарыг дэмжиж байна. өөр саналгүй

Д.Сайнжаргал: Б.Батбаярыг дэмжиж байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн даргаар Б.Батбаярыг сонгов.

Ц.Байгалмаа: ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар даргаар сонгогдсон тул үргэлжлүүлэн хурлаа удирдаад явна уу.

Б.Батбаяр: Гишүүддээ баярлалаа. Урьд нь даргаар ажиллаж байсангүй. Эрчимийн ТУЗ-д гишүүнээр ажиллаж байсан. Намын бүлгийн саналыг хүлээн авч сонгосонд баярлалаа. ТУЗ байгуулагдаад даргаа сонгоод процессийн хувьд одоо ямар асуудал шийдэх ёстой талаар нарийн бичиг мэдээлэл өгнө үү.

Ч.Мягмарсүрэн: Гүйцэтгэх захирлаар томилогдох саналтай хүний мэдээлэл орж ирэх байх.

Б.Батбаяр: Аймгийн ИТХ-д 3 удаа сонгогдсон, Засаг даргын орлогчоор ажиллаж байсан М.Мөнхбатыг гүйцэтгэх захирлаар томилох санал орж ирж байна.

Гишүүд саналаа илэрхийлнэ үү.

П.Дашзэвэг: Мөнхбат даргын хувьд ажлын чадамж, хувь хүн талаас татгалзах зүйл алга. Намын бүлэг дээр яригдаж байгаа зүйл арай өөр байгаа учир санал хураалтанд оролцохгүй. Татгалзая

Д.Даваадорж. Дэмжиж байна Цаашид хамтраад ажиллана

Л.Мандал. Дэмжиж байна.

Ч.Үйтүмэн: Дэмжиж байна.

Ц.Төмөрбаатар: Татгалзах зүйл алга дэмжиж байна.

Ц.Байгальмаа Дэмжиж байна.

Б.Батбаяр: Миний хувьд мөн дэмжиж байна. Хуралд оролцож буй гишүүд гараа өргөөд санал хураая.

| № | ТУЗ-ийн гишүүний овог нэр | Санал өгсөн байдал | | |
|---|---------------------------|--------------------|--|------------|
| | | Зөвшөөрсөн | Санал хураалтанд оролцохоос татгалзсан | Түтгэлзсэн |
| 1 | П.Дашзэвэг | | + | |
| 2 | Л.Мандал | + | | |
| 3 | Д.Даваадорж | + | | |
| 4 | Ц.Байгалмаа | + | | |
| 5 | Ч.Үйтүмэн | + | | |
| 6 | Б.Батбаяр | + | | |

Онлайнгаар оролцож буй 2 хүний саналыг авъя.

Ц.Төмөрбаатар: Татгалзах зүйлгүй. Дэмжиж байна.

Д.Сайнжаргал: Мөнхбатыг дэмжиж байна.

| № | ТУЗ-ийн гишүүний овог нэр | Санал өгсөн байдал | | |
|---|---------------------------|--------------------|------------|------------|
| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түтгэлзсэн |
| 1 | Ц.Төмөрбаатар | + | | |
| 2 | Д.Сайнжаргал | + | | |

Шийдвэрлэсэн нь: Танхимаар оролцсон гишүүдийн 5 дэмжиж, 1 гишүүн санал өгөхөөр татгалзаж, онлайнаар олоцсон 2 гишүүн дэмжлээ.

Б.Батбаяр: Олонхийн саналаар М.Мөнхбатыг гүйцэтгэх захирлаар томилохыг дэмжлээ.

Э.Энхбат: Хурлын зүгээс Чандмань-Баянхонгор ХК-ийг ХХК болгохоор дүрмийг нь өөрчилж оруулж ирнэ. Үндсэн үйл ажиллагаа нь ХХК-иар яваад байдаг, нэр нь ХК байгаад байдаг. Дүрмээ өөрчлөөд саналаа оруулж ирээрэй. ТУЗ-ын дарга, гишүүд нартаа ажлын амжилт хүсье. Өөр зүйлгүй.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧИГ



Ч.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН

ТУЗ-ЫН ДАРГА:



Б.БАТБАЯР